

11

Мал аж ахуйн бүтцийн бизнес хөгжлийн асуудал

К.Аксолтан

Мал аж ахуйн бүтэц нь байгаль, нийгэм, эдийн засаг, зан заншил, хөгжлийн түвшин зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай оршдог. Тэдгээрээс хамгийн шийдвэрлэгч нөлөөтэй нь зах зээлийн хэрэгцээ юм.

Ер нь таван хошуу малын нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, ач холбогдол нь харилцан адилгүй мөртлөө ийм олон төрлийн малыг зэрэгцүүлж өсгэх нь бас л зайлшгүй хэрэгцээтэй байсан хэрэг. Энэ нь өнгөрсөн түүхийн хугацаанд малын төрөл тус бүр дээр янз бүрээр илэрч иржээ. Тухайлбал, агт морь нь цэрэг дайны болон өртөө улааны үүрэг гүйцэтгэдэг байсан дээр үед адуу шиг өндөр ач холбогдолтой мал байгаагүй. Хожим нийгэм хотжин хөгжжик суурьшаад ирэхийн цагт мах, сүү зэрэг бүтээгдэхүүний хэрэгцээ ихээхэн нэмэгдэж энэ нь улмаар сүүлийн дечеөөд жилд адууг бодвол үхэр сүргийг илүүд үзэж өсгэх сонирхлыг төрүүлэх болсон. Тэгвэл 1990 оноос хойших зах зээлийн тогтолцооны үед ноолуурын хэрэгцээнээс үндэслэн ямаан сүргийн тоо их эрч хурдацтай өсөж нэмэгдэх боллоо. Харин хонин сүрэг Монгол орны амьдралд ямагт тэргүүн зэргийн үүрэгтэй байсан онцлогтой. Иймд тухайн үеийн нийгэм эдийн засгийн хэрэгцээ ямар төрлийн малын бүтээгдэхүүн, ашиг тусыг илүүд үзнэ үү малчид тэр л төрлийг өсгөж үржүүлэх сонирхолд илүүтэй хөтлөгддөг нь зүй ёсны асуудал билээ.

Гэхдээ энд онцолж анхаарвал зохих нэг асуудал бий. Юу гэвэл: Манайх бэлчээрийн нүүдлийн МАА-тай орон учраас түүнийг үнэмлэхүй өсгөх зорилго эдийн засгийн сонирхолоос гадна тэдгээрт тохиромжтой байгаль экологийн нөхцлөөр давхар хязгаарлагдаж байдаг гэдгийг мартаж болохгүй. Бизнесийн үүднээс эзэндээ ашиг орлого ихтэй малын төрлийг илүүтэй өсгөж үржүүлэх бодлого барьж болно, тэгэхдээ түүний нийт сүргийн дотор байх тоо, хувийн жинг бэлчээр нутгийг талхалж, байгаль болон бусад төрлийн малд сөрөг нөлөөлөл учруулахгүй түвшинд барьж тохируулж байх ёстай. Яагаад гэвэл, ийм болгоомжлол ТХМ-ын дотроос ямаа, адуу зэрэг бэлчээрт сөрөг нөлөөлөл ихтэй малд илүүтэй хамарагдаж байгаа юм.

Адуу хүчтэй, хатуу турайгаараа хөрс, бэлчээрийг гишгэлж талхлах юмуу цастай үед цавчиж өвс тэжээлээ олж иддэг бол ямаа хурц турайтай, идэмхий, өвсний үндсийг нь гаргал мөлждөг учраас сүйтгэлтэй мал гэж үздэг. Иймд энэ хоёр төрлийн мал хэт олширвол бэлчээр талхлагдаж халцрах, өвс ургамал нь хомсдож, цөлжилт үүсэх аюултай гэдэг юм. Дээр үед ямааг хэт өсгөснөөс дэлхийн улс орнуудад ийм эмгэнэлт явдал тэхиолдож байсан гашуун туршлага, түүх, сургамжууд ч байна.

Тус орон зах зээлийн эдийн засаг (33ЭЗ)-т шилжиж байгаа өнөө үед МАА-н зарим салбарын бүтэц бизнес-экспортод ашигтай боловч ерөнхийдөө байгаль-экологид халгаатай чиглэлээр түргэн өөрчлөгдж байгаа нь анхаарал татаж байна. Тухайлбал, ямаан сүргийн өсөлтийг үүний жишээ болгон нэрлэж болно. Тус орон нээлттэй, чөлөөт худалдаа бүхий зах зээлийн тогтолцоонд шилжиж, манай малаас гардаг ноолуур гэдэг өвөрмөц ховор бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд өндөр үнэ ханшаар худаллагдах болсноор тус орны ямааны тоо 1990 оноос хойших 9 жилийн дотор (1990-1999) 5.9 саяар буюу бараг 2.2 дахинаар өслөө. Одоо ТХМ-ын 1/3 гаруйг (2001 онд 36.8%) ямаа эзлэх болсон бөгөөд 1990 онд 3:1 байсан хонь, ямааны тооны харьцаа 1999 онд 1.35:1, 2001 онд 1.24:1 болтол хонины тоо цөөрч багасаад байна. Уг нь дээр үеэс тогтох ирсэн уламжлалаар бол энэ хоёр малын тооны харьцааг 5:1 юмуу 4:1 гэсэн зарчмаар тохируулдаг байсан гэж үздэг. Сүүлийн 70 гаруй жилийн (1918-1990) байдлаас түүвэрлэн харьцуулж үзвэл (арав, арван жилээр) хонь, ямааны тооны зохицол нь их төлөв 3.8:1-ээс 2.9:1-ийн хооронд хэлбэлзэж байсан байна.

МАА-н уламжлалт бүтэц нь манай байгаль, цаг уурын хатуу, ширүүн нехцөлд нүүдэлчдийн ахуй амьдралд нийцүүлэн ТХМ-ыг шүтэлцүүлэн өсгөж үржүүлэхэд үнэхээр алтан дунджийг олж зөв тохируулсан зүйл мөн боловч орчин үеийн нийгмийн хөгжлийн хандлага, хэрэгцээ шаардлага нь тэрхүү бүтцэд байгаа зарим төрлийн малын тоо, харьцааг ойртуулж зааг ялгааг нь улам багасгасаар байна.

Түүнээс гадна Монголчууд адуу, хонь хоёроо мөн тэнцвэртэй өсгөж, МАА-нхаа бүтэц бүрэлдэхүүнийг тохируулж ирсэн ухаантай ард түмэн. Түүхэнд тэмдэглэнээр "Нэг морь байвал түүнийг дагаж 6-7 хонь байх ёстой." гэж үзэж байж. Сүүлийн 80 гаруй жилийн (1918-2001) байдлаас түүвэрлэн харьцуулж үзэхэд адуу, хонь хоёрын тоо ихэнхдээ 1: (5-7)-ийн хооронд хэлбэлзэж иржээ. Өөрөөр хэлбэл, 800 гаруй жилийн өмнө тогтоож байсан тэр харьцаа өнөөдрийг хүртэл дагаж мөрдөгдсөөр байгаа нь сонирхол татаж байна. Үүнээс бэлчээрийн нүүдлийн МАА бараг 100 хувь байгалиас хараат аж ахуй учраас Монголчууд бүр эрт дээр үед тэдгээрийн төрөл хоорондын бүтэц харьцааг тогтоохдоо эдийн засгийн үр ашигийг бодолцохоос өмнө байгаль экологийн зохицлыг илүүтэй харгалзаж үздэг байжээ гэдэг нь тодорхой байна.

Судлаачдын тооцоолж байгаагаар Монгол нутагт ямаа үржүүлэхэд тохиромжтой байгаль экологийн дээд боломжийг 11.0-13.5 сая толгой буюу 2900-3500 тонн ноолуураар тогтоож байх шиг байна. Энэ нь нийт малын тоо 2002 оных шиг 23.6 сая болж буурвал 46.0-57.2 хувь, бидний прогнозлож байгаачлан 40 саяд хүрч өсвөл 27.5-33.7 хувийг эзэлнэ гэсэн үг. Ямартай ч ноолуур нь өндөр ашиг орлоготой, өрсөлдөх чадвартай, экспортын ховор бүтээгдэхүүнд тооцогддог учир зах зээлийн нехцөлд ямааг тийнхүү олноор

өсгөж үржүүлсэн нь хэдийгээр ТХМ-ын ялангуяа, хонь ямааны хоорондын уламжлалт бүтцийг эвдэж байгаа ч гэсэн хөдөөгийн хүн амын амьжиргаа, экспорт-бизнесийн үүднээс зайлшгүй ашиглах ёстой нөөц байсан гэж бодож байна. Хэрэв байгаль цаг уурын талаас ноцтой өөрчлөлт гарахгүй бол нэгэнт ямаанд тохирсон нутаг нь байхад түүнийг дээд боломж нь буюу 12-13 саяд хүртэл өсгөж экспортын нөөц бололцоогоо өргөтгөх нь зүйтэй гэж үзэж байна. Одоо ямааг олноор өсгөх болсон нь нэг талаас, бэлчээрийн нүүдлийн МАА-н зүй тогтоос гажиж байгаа юм шиг (мэт) санагдавч нөгөө талаас, ямааны тоо нь түүнд тохирох бэлчээр нутгийн хүрээнээс (даацаас) хальж гаралгүйгээс гадна бид хонио өсгөх ихээхэн боломжоо бас бүрэн гүйцэд ашиглаж чадаагүйгээс энэ хоёрын харьцаа хэт ойртох болсныг хэлэх хэрэгтэй.

Зах зээлийн эдийн засаг нь хонь, ямааны хоорондын харьцаа буюу ер нь энэ хоёр төрлийн малын өсөлтөнд зэрэг, сөрөг хоёр талтай нөлөө үзүүлж ирснийг бид бүхэн мэдэж байна. Тухайлбал, хөдөө орон нутагт хонь төлбөрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэсээр байгаа нь түүний зарлагыг нэмэгдүүлж, өсөлтийг бууруулахад нөлөөлж буй хамгийн том хүчин зүйл юм. Хоёрт, бүтээгдэхүүний хувьд хонины мах, арьс нь өндөр үнэлэгддэг ч тэрхүү орлогыг гагцхүү нядалж байж олж авдаг болохоор зах зээлийн урсгал нь хонины хувьд тоо толгойгий нь баагасгаж, хороцуулах чиглэлээр нөлөөлсөн бол ямааны ноолуур нь түүний тоо толгойг өсгөж улам олон болгох сонирхлыг хөхүүлэн урамшуулсан юм. Хонь, ямаанаас авах ашиг орлогын талаархи эдгээр зөрчилтэй сонирхол нь энэ хоёр малын тооны харьцааг өнөөдөр 1:24:1 болтолтой ойртуулаад байна.

ТХМ-ын бүтэц харьцаанд гарч байгаа дээрх өөрчлөлтүүдийг зөвхөн эрдэмтэд ч биш мэргэжлийн хүмүүсийн хүрээнд ч их телөв тааламжгүй хүлээж авдаг. Үүний учир шалтгааныг, бидний дээр дурдсанаас гадна ямаа нь хонины нөмөр нөөлөгөнд амьдардаг, ямаа ихэдвэл хот хороо хөлдөнө, ямаа цөлжилтийг зөгнөдөг, ямаа ихэдвэл хонио дагуулж гүйгээд тарга хүчийг нь муутгадаг гэхчлэнгээр маш олон үндэслэлээр тайлбарладаг. Ийм сөрөг талыг үгүйсгэхгүй боловч миний хувьд эл хандлагыг нийгэм, эдийн засгийн хөгжлийг дагаж МАА-ын салбарын бүтцэд гарч буй зүй ёсны дэвшилтэд өөрчлөлт гэж дүгнэж байна. Хонь, ямаа хоёрын тооны харьцаа бараг адил тэнцүү хэмжээнд хүртэл ойртон нь өнөөдрийн тогтолцооны бодит үзэгдэл. Тодорхой хэрэгцээ, тохиромжтой нутаг нь байсаар байтал экологийн шалтгаанаар тухайлсан бус нутгуудын ямааг цөөлж хонийг нь өсгөнө гэдэг санасны зоргоор шийдэх асуудал биш бөгөөд харин улсын хэмжээгээр бол эдгээр малын тоог уламжлалт харьцаанд ойртуулж сайжруулах боломж бий. Учир нь ямаан сүргийн тоо, бэлчээр, экологийн тохиромжтой боломжиндоо бараг тулж ирчихээд байхад хонин сүргийг үлдсэн бэлчээрийн неөөцдөө тулгуурлан дахиад 10-15 саяар нэмж өсгөх бололцоо байсаар байна. Өөрөө хэлбэл, Монгол улс 25 сая хонь, 12 сая ямаатай байхад тэдгээрийн хооронд 3:1 биш юмаа гэхэд 2:1 харьцааг хангаж болно гэсэн үг.

Ер нь ТХМ-ын төрөл бүр нь янз бүрийн түүхэн цаг үеуд дэх өөрийн үүрэг, ач холбогдлыг нийт сүргийн дотор эзлэх тоо, хувийн жингээрээ илэрхийлж ирсэн түүхтэй юм. Тухайлбал, XIII зууны үед Монголын МАА-г хонь, адуу хоёр тэрчүүлж байсан бол XX зуунд хонь, үхэр, зах зээлийн тогтолцоонд орсон XXI зууны эхэнд хонь, ямааны тооны харьцаа үлэмжхэн ойртох ирээд байна. Үүнээс

өмнөх аль ч нийгэм манай ТХМ-ын бүтцэд ийм эрс өөрчлөлт (хувьсал) гаргаж байгаагүй. Энэ бол зах зээлийн тогтолцоот нээлттэй, чөлөөт нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодит шаардлага. Хэрэв эрэлт хэрэгцээ өөрчлөгдвэл зохих байгаль-экологийн нөхцлийн хүрээнд ТХМ-ын бүтэц цаашдаа ч хувьсан хөгжжик ямааны байр суурийг өөр өөр төрлийн мал эзлэн солигдохыг үгүйсгэх аргагүй.

МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд салбарын бүтцээс гадна сүргийн дотоод бүтцэд оршдог далд нөөцийг зөв зохицуулж ашиглах нь онцгой ач холбогдолтой. Аливаа үйлдвэрлэл хэрэгцээг харж өөрийн бүтцийг тодорхойлдог гэдгийг бид түрүүн хэлсэн. Тэгвэл Монголчууд МАА-н хувьд харьцаангуй бүдүүн насты эр мал олонтой сүргийн бүтцийг чухалчилж үзсээр ирлээ. Ийм хэрэгцээ нь цаагуураа олон зүйлийн шалтгаантай, холбоотой нь ойлгомжтой. Тухайлбал: Нэгд, Монгол орон хатуу ширүүн цаг улиралтай учраас малчид өвлийн цагт аль болох уураг, илчлэг ихтэй (өөх тостой) том малын махыг хүнсэндээ хэрэглэхийг хүсдэг. Хоёрт, бүдүүн насты эр мал ихтэй сүрэг байгалийн цас, зудны аюулыг даван туулах чадвар сайтай, өсвөр бага мал түүний нөмөр нөөлөгөнд хоргодж зутрах нь бага байдаг. Гуравт, нүүдэлчин сэтгэхүй, үндэсний өвөрмөц ёс заншилаар бол төл, өсвөр бага насты малыг шүүсэлж хэрэглэх биш харин үржүүлэхийг эрхэмлэдэг билээ. Энэ нь магадгүй нутгийн үүлдрийн мал өсвөр насандаа жин, махны гарцаар бага байдагтай ч холбоотой байж болох юм.

Монголчууд үеийн үед ингэж явж ирсэн. Мал, махыг ихээр экспортлож байсан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бэлтгэлийн малын наас, шуд нэлээд залуужиж жижгэrsэн боловч уламжлалт бүтцийг эвдэхээр хэмжээний нөлөө бас л үзүүлж чадаагүй юм. Гэвч дэлхийн худалдааны хөгжлийн аясыг дагаж XXI зуунд дээрх тогтсон хатуу бүтэц, хүн ардын дадал, заншлыг цаашдаа ямар нэг хэмжээгээр зөвлүүлж өөрчлөх хэрэгцээ аяндаа гарах нь шиг байна. Учир нь нэгд, өнөөг хүртэл (нүүдлийн ахуй амьралд тохиуулж) сүргийн бүтцийг бүрдүүлэхэд баримталж ирсэн байгаль, нийгэм, эдийн засгийн нөхцлүүд одоо их өөр болжээ. Дан нүүдэлчин байсан Монгол орон эдүгээ хот, хөдөө зэрэгцсэн хоёр соёл иргэншилд хуваагдан амьдардаг боллоо. Энэ нь МАА-н бүтээгдэхүүний (махны) хувьд хүн амын өөр өөр эрэлт хэрэгцээг бий болгож байгаа учраас түүнийг мал сүргийн дотоод бүтцэд бүр тодруулж хэлбэл, маханд бэлтгэх малын наас, хүйсийг сонгоходоо харгалзаж үзэхээс өөр аргагүй болгож байна. Хоёрт, дэлхийн байгаль, цаг уурын дулаараптай холбогдож манайд ч эрс өөрчлөлтүүд гарч эхэлж байна. Үнд: нэг талаас, хүйтний улирлын үргэлжлэх хоногийн тоо цөөрч, эрч хүч нь суларч, халуун өдрийн тоо нэмэгдэж байгаа бол негеэ талаас, огцом огцом хүйтэрч хэт их цас орж, удаан хугацаагаар цасан бүрхүүл тогтох зэргээс бэлчээрийн МАА-д үзүүлэх таагүй үзэгдлийн тоо, үргэлжлэх хугацаа ч бас нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, нэг хэвийн нүүдлийн МАА эрхлэх боломж байгаль цаг уурын талаас нэлээд тогтвортгүй хувьсамтгай болж байна. Гуравт, Монгол улс XXI зуунд урьд өмнө явж ирсэн бүх нийгмээс үндсээрээ ялгаатай 33ЭЗ-ийн тогтолцоот нийгэмд амьдарч аж төрөх нь тодорхой. Улам бүр даяаршин гүнзгийрч байгаа дэлхийн эдийн засаг, худалдааны системд Монгол улс өөрийн эзлэх байрыг зөв олж авахын тулд цаашид нүүдэлчин ахуй амьдралаас уламжлагдаар байгаа МАА-н олон асуудалд (ашиг шим, бүтэц, нас хүис г.м) цоо шинээр хандах шаардлага тулгарч

байна. Эдгээр бүх зүйлс нь зөвхөн махан бүтээгдэхүүний хувьд гэхэд л түүний дотоодын хэрэглээ, экспорт, бүтэц, найрлага, чанарт тавих шаардлагыг эрс өөр болгож байна. Монгол мал өөх ихтэй, мах, өөх нь тус тусдаа ялгаран тогтдог онцлогтой. Амьдрал дээр хүүхэд, залуучууд (ялангуяа хотын) ийм өөхлөг маханд дургүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөөр барахгүй цаашдын мал ёсгэж, мах үйлдвэрлэх бодлогодоо харгалзах ч хэрэгтэй байх. Яагаад гэвэл, махны дээрх өвөрмөц хэрэглээг гол захиалагчид болох хүүхэд, залуучууд (35 хүртэлх насын) 2000 оны байдлаар манай хүн амын 72.8 хувийг бүрдүүлж байгаа юм. Дөрөвт, тус оронд МАА-г эрчимжүүлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага ч урьд урьдаас улам хүчтэй тавигдаж байна.

Мах импортлогч орнууд манай малын махыг хөгшин, хатуу, булчинлаг, өөх ихтэй гэж голоод, тэд аль болох өөхгүй (эсвэл алагласан өөхтэй) зарим нь бүр туранхайдуу, зөвлөн, өсвөр малын (тугал, хурга, их сайндаа бяруу, төлөг, борлонгийн) мах авахыг хүсэж байна. Арабын орнууд шашин, шүтлэг, ёс заншлаасаа хамаараад бага насын амьд мал импортлон авахыг сонирхдог явдал ч байна. Нэгэнт хэрэгцээ ийм байгаа болохоор нутгийн үүлдрийн малын өсөлтийг богино хугацаанд гүйцээж томруулах, орчин үеийн шинэ дэвшилтэд технологийг судалж нэвтрүүлэх шаардлага ч их байна. Энэ бүхнээс үзэхэд манай малын, сүргийн дотоод бүтцэд дээрх эрэлт шаардлагад нийцүүлэн зохих өөрчлөн сайжруулалт хийх (бага насын малыг маханд бэлтгэх, экспортлодог болох, эх ба төл малын эзлэх хувийг нэмэгдүүлэх зэргээр) цаг нэгэнт бүрджээ гэсэн дүгнэлт гарч байна. Ийм дэвшилтэд бүтцийг тэмээнээс бусад бүх төрлийн малд зохих зааг, ялгаатайгаар хэрэглэж болох юм.

Энэ бол төл малыг олон жил бэлчээрээр маллаж тэжээхэд байгаль цаг уурын нөхцөл тааламжгүйгээр эргэж (өөрчлөгджэ) байгаа одоо үед сүргийн дотоод бүтцийг өсвөр бага насын малаар баяжуулж махны экспортод гаргахад хамгийн тохиромжтой цаг үе ирээд байх шиг санагдана. Хэрэв бид малыг өсвөр бага насанд нь (хурга, тугал байх үед) экспортлох найдвартай зах зээлийг олж чадвал өвөл, хаврын цас, зуд, өвс тэжээлийн хомсдолыг дайруулахгүйгээр шим шүүслэг тэжээлтэй зун, намрын дулаан улиралд бэлчээрээр таргалуулан маханд борлуулж малын зүй бус хорогдлыг эрс багасган, махны үйлдвэрлэлийн экспортыг үлэмжхэн нэмэгдүүлэх цоо шинэ бололцоо нээгдэж болзошгүй байна. Энэ нь бас өөр хоёр талын ач холбогдолтой. Үүнд: Нэгд, махны чиглэлийн эрчимтэй аж ахуйных шиг сүргийн дотор эзлэх хээлтэгч малын тоо, хувь хэмжээ эрс өсч нэмэгдэнэ. Үүний урээр бойжуулж авах төлийн тоо (малын төрлөөс хамаарч өөр өөр байх боловч) наад зах нь 50 хувь магадгүй түүнээс ч илүүгээр өсөх боломжтой. Хоёрт, ялангуяа төл малын хорогдол эрс буурах буюу зарим тохиолдолд бараг байхгүй шахам болж, өвөл, хаврын тарчиг хомс бэлчээрийн нөөцийг үндсэндээ үржлийн зориулдаттай малд ашигладаг болсноор бэлчээрийн хүрэлцээ, үндсэн сүргийн малын үр өгөөж үлэмжхэн дээшлэх болно.

Энэ бүхнээс үндэслээд хэрэв бид цаг үеийн шаардлагыг зөв ойлгож зоригтой хөдөлбөл XXI зууны эхний хагас зуун жилд шаардагдах махны хэрэгцээт нөөцийн өсөлтийн нэлээд хэсгийг ТХМ-ын салбарын болон ялангуяа, сүргийн дотоод бүтцийн сайжралтаас (өөрчлөлтөөс) гаргаж авч болох юм гэсэн дүгнэлт хийж болохоор байна.